АЙМАГ, НИЙСЛЭЛ, НИЙСЛЭЛИЙН
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА, ЖЕНДЭРИЙН
САЛБАР ХОРООНЫ ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛС
**ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО**
Нэгдсэн үндэстний гудамж 20, 6-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 70071113, 70071117
Цахим шуудан: secretariat@ncge.gov.mn,
Цахим хуудас: www.ncge.gov.mn

2025.05.30 № 141
танай ____________-ны №____________-т

Хяналт-шинжилгээ, үнэлгээний
тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай

Жендэрийн үндэсний хороо нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, тусгай арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх эдийн засаг, эрх зүйн баталгааг бүрдүүлэх, түүнийг боловсруулах ажлыг арга зүйн удирдлагаар хангаж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагатай нягт хамтран ажиллаж байна.

ЖЭТБХтХ-д заасны дагуу нутгийн захиргааны байгууллага нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайланг жил бүр Хороонд тайлагнадаг бөгөөд тайланг Говьсүмбэр, Өмнөговь, Сүхбаатар, Увс аймаг, Сонгинохайрхан, Баянгол дүүрэг ирүүлээгүй, 16 аймаг, нийслэл, дүүрэг хугацаандаа ирүүлсэн, Баянхонгор, Дорноговь, Орхон, Ховд аймаг, Багахангай, Баянзүрх, Налайх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг хугацаа хоцроож ирүүлснийг хүлээн авч, хяналт шинжилгээ хийж үүгээр хүргүүлж байна.

ЖЭТБХтХуулийн 19 дүгээр зүйлд заасан нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг, 10 дугаар зүйлд заасан төрийн албанд жендэрийн тэгш байдлыг хангах баталгааны хэрэгжилтийг хангах хүрээнд 2024 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үйл ажиллагааны болон хүрэх үр дүнгийн 14 бүлэг, 46 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд нутгийн захиргааны байгууллагын дундаж 55.3% буюу 2023 оны үнэлгээнээс 3.5 хувиар буурсан байна.

Үнэлгээний нэгдсэн үзүүлэлтээр Ховд, Төв аймаг 70-аас дээш хувь, Багахангай дүүрэг 69.7 хувийн хэрэгжилттэй байна. Архангай, Хэнтий, Дорноговь, Баян-Өлгий, Өвөрхангай, Говь-Алтай, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, Багахангай, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүрэг тус тус өмнөх онтой харьцуулахад ахиц дэвшилттэй байна.

Цаашид орон нутгийн болон байгууллагын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх, хүрсэн ахиц дэвшлийг хадгалах, ахиулах замаар хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллана уу.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн 2024 оны хэрэгжилтийн хяналт-шинжилгээний нэгдсэн тайлан, зөвлөмжийг хавсаргав.

Хавсралт: 38 хуудастай.

Хамтын ажиллагаанд талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Т.ЭНХБАЯР

УЛААНБААТАР ХОТ
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО
9024041451 9517381 СТ323

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

# ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ, ОРОН НУТГИЙН ЖЕНДЭРИЙН БОДЛОГО, СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар
2025 он

ГАРЧИГ

Товчилсон үг ... 3

Хүснэгт, зургийн жагсаалт ... 4

НЭГ. УДИРТГАЛ ... 5

1.1. Хяналт шинжилгээний зорилго ... 5

1.2 Хяналт шинжилгээний хамрах хугацаа ба хүрээ ... 5

1.3 Хяналт-шинжилгээний аргачлал ... 5

1.4. Тайлан ирүүлсэн ирц, чанар ... 6

1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний товч үр дүн ... 8

ХОЁР. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН ... 9

2.1 Жендэрийн хариуцлагатай бодлого төлөвлөлт: Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, ахиц дэвшил ... 9

2.1.1.Жендэрийн хариуцлагатай төсөвлөлт: үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, зарцуулалт: ... 11

2.1.2. Жендэрийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа: ... 13

2.1.3. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо манлайллыг нэмэгдүүлэх, түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хэрэгжилт ... 17

2.1.4. Хөдөлмөрийн харилцаан дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль, бодлогын хэрэгжилтийг дэмжих зорилтын хэрэгжилт ... 17

2.2. Нутгийн захиргааны байгууллагын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, ахиц дэвшил ... 18

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ ... 20

Хавсралт 1. Нутгийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, аймгаар (2024 оны жилийн эцсийн байдлаар) ... 23

Хавсралт 2. Нутгийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, нийслэл, дүүргээр (2024 оны жилийн эцсийн байдлаар) ... 28

Хавсралт 3. Хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ (аймаг, нийслэл) ... 33

Хавсралт 4. Хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ (дүүрэг) ... 34

Хавсралт 5. Нутгийн захиргааны байгууллагаас жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан (аймаг, нийслэл, нийслэлийн дүүрэг ... 35

Ашигласан материал ... 37

**Товчилсон үг**

| | |
|---|---|
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БОАЖЯ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| БХЯ | Батлан хамгаалах яам |
| БХБЯ | Барилга, хот байгуулалтын яам |
| БШУЯ | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| БЕГ | Боловсролын ерөнхий газар |
| ГХЯ | Гадаад харилцааны яам |
| ГЗБГЗЗГ | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЖҮХ | Жендэрийн үндэсний хороо |
| ЖҮХАА | Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын алба |
| ЖЭТБХ | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах |
| ЖЭТБХтХ | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль |
| ЗГҮАХХАХ | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ЗТХЯ | Зам, тээврийн хөгжлийн яам |
| ЗХЖШ | Зэвсэгт хүчний жанжин штаб |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НЗБ | Нутгийн захиргааны байгууллага |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| НҮБХАС | Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан |
| ОСЖҮ | Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТОСК | Төрийн орон сууцны корпораци |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| ТӨААТҮГ | Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| УУХҮЯ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам |
| ХШҮДАГ | Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар |
| ХШҮХ | Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс |
| ХШҮ | Хяналт-шинжилгээ, үнэлгээ |
| ЦХХХЯ | Цахим хөгжил, харилцаа холбооны яам |
| ШХА | Швейцарын хөгжлийн агентлаг |
| ЭЗХЯ | Эдийн засаг, хөгжлийн яам |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭХЯ | Эрчим хүчний яам |
| ЭАБК | Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс |

**Хүснэгт, зургийн жагсаалт**

Хүснэгт 1. Цахим тайлан шивсэн бүртгэл 2021-2024
Хүснэгт 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн бичмэл тайлан ирүүлсэн бүртгэл, 2024
Хүснэгт 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн мэдээ
Хүснэгт 4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төсөв зарцуулсан яам, нутгийн захиргааны байгууллагын тоо
Хүснэгт 5. Сургалтад оролцогч, хүйсээр
Хүснэгт 6. Удирдах ажилтанд зориулсан цахим сургалтад хамрагдсан байдал, аймгаар
Хүснэгт 7. Удирдах ажилтанд зориулсан цахим сургалтад хамрагдсан байдал, дүүргээр
Хүснэгт 8. Нутгийн захиргааны байгууллагын ЖЭТБХтХ-аар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн нэгтгэл дүн

Зураг 1. Сургалтын тоо, хамрагдсан байгууллагаар
Зураг 2. Удирдах ажилтанд зориулсан цахим модуль болон Иргэд, олон нийтэд зориулсан жендэрийн цахим тест
Зураг 3. Иргэд, олон нийтэд зориулсан тестэд хамрагдсан байдал, аймаг, нийслэлээр
Зураг 4. ЖЭТБХтХ-аар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт (аймгийн түвшинд)
Зураг 5. ЖЭТБХтХ-аар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт (Нийслэл, нийслэлийн дүүргийн түвшинд)

## НЭГ. УДИРТГАЛ

### 1.1. Хяналт шинжилгээний зорилго

Хяналт-шинжилгээний зорилго нь нутгийн захиргааны байгууллагын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, орон нутгийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, энэ хүрээнд холбогдох зөвлөмж гаргахад оршино.

### 1.2 Хяналт шинжилгээний хамрах хугацаа ба хүрээ

Хяналт шинжилгээг ЖЭТБХтХ, орон нутгийн жендэрийн бодлого, тэдгээрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ, үйл ажиллагааг хамруулан 30 хоногийн хугацаанд түргэвчилсэн байдлаар хийж гүйцэтгэлээ.

### 1.3 Хяналт-шинжилгээний аргачлал

Тус хяналт шинжилгээний тайлан боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ хийх заалтуудыг удирдлага болгож, үр дүнгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтээр тооцож үнэллээ. Орон нутгийн жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлт, төсөвлөлт, гүйцэтгэл, хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн эсэх болон орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтөд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлэх арга хэмжээ авч, үр дүнг иргэд олон нийтэд тайлагнасан, ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох арга хэмжээ авсан эсэх, хуульд заасан квотын хэрэгжилт хангагдсан эсэх зэрэг 14 бүлэг 46 шалгуурыг тооцсон.

Хяналт шинжилгээ, үнэлгээний явцад нутгийн захиргааны байгууллагын тайлан, мэдээнд үнэлэлт өгөхөөс гадна тухайн жилд зохион байгуулсан семинар, уулзалт, жендэрийн мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, хурал, тус ажлын албанаас зохион байгуулсан аян, бусад төлөвлөгөөт арга хэмжээний оролцоо болон салбар орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангаж буй байдлыг харгалзан явцын хяналт шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

Үр дүнгийн шалгуурт Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр тооцдог "жендэрийн ялгаатай байдлын үзүүлэлт"-ийн эдийн засгийн оролцоо боломжийн үзүүлэлт: эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо болон нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг нэмж тооцсон болно.

***Нэгдсэн оноо:*** Дээрх бодлогын хэрэгжилтийн шалгуур бүр бүгд ижил ач холбогдолтой гэж үзэн, ижил жин өгч, үйл ажиллагааны үндсэн чиглэл бүрийн нэгдсэн оноог энгийн, жинлээгүй дунджийн аргаар тооцов. Нийт 14 бүлэг 46 шалгуурын хүрээнд "арга хэмжээ аваагүй" бол 0, "зорилтот арга хэмжээ авсан" бол 100 оноо өгөх замаар үнэлэв. Үүнд:

$$A_i = \frac{q_1 + \cdots + q_n}{n}$$

*Энд,*
*Ai* – тухайн бүлгийн хэрэгжилтэд өгсөн дундаж оноо
$q_1+...+q_n$ - нь үйл ажиллагааны шалгуур бүрт өгсөн оноо
n- тухайн бүлгийн нийт шалгуурын тоо

12 бүлэг тус бүрийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн $\langle A_1, A_2, A_3, A_4 \rangle$ дундаж оноог тооцсон ба энэ нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийн цогц үнэлгээг харах боломжийг бий болгоно.

**<u>Үнэлгээнд ашигласан мэдээллийн эх үүсвэр, мэдээлэл цуглуулалт</u>**

Хяналт шинжилгээнд шаардлагатай тоо мэдээлэл, баримт материалыг цуглуулах, боловсруулахдаа дараах арга зүйг ашигласан. Үүнд:

**Хоёрдогч мэдээллийн эх үүсвэр:**

ЖЭТБХтХ-д заасан нутгийн захиргааны байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайлан, 2024, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын хүйсээр ангилсан мэдээлэл, 2024, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяны тайлан мэдээ, 2024, Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027) -танилцуулах арга хэмжээний ирц, оролцооны талаарх тайлан илтгэх хуудас, Үндэсний статистикийн хорооны мэдээллийн нэгдсэн сан, болон ЖҮХ-ны холбогдох тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмжийн хэрэгжилт, үйл ажиллагааны бусад тайлан мэдээлэлд шинжилгээ хийж гүйцэтгэлээ.

**Анхдагч мэдээллийн эх үүсвэр:**

Сургалт, уулзалт, аян, танилцуулах бусад танхимын болон цахим арга хэмжээний оролцоо, ЖҮХ-ны Ажлын албаны орон нутгийн хөгжлийн бодлого зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлага зэргийг харгалзан үзсэн болно.

**Үнэлгээнд тулгарсан хүндрэл бэрхшээл, хязгаарлагдмал байдал**

Нутгийн захиргааны байгууллагын жендэрийн салбар хорооноос жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, бодлого, стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тодорхой тусгаагүй, санхүү төсвийн талаарх задаргаатай, тайлагналт байхгүйгээс үр ашгийн төлөв байдал (зардлыг үр өгөөжтэй харьцуулсан шинжилгээ)-ыг тодорхойлох боломжгүй хэвээр байна.

Түүнчлэн жендэрийн салбар хорооны дарга, салбар хорооны нарийн бичгийн дарга бөгөөд жендэрийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолт ЖЭТБХтХ-д заасан нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийг зохион байгуулахад хүрэлцэхүйц цаг хугацааны нөөцийг хуваарилаагүй, зарим аймаг, дүүргийн жендэрийн мэргэжилтэн хэд хэдэн чиг үүрэг хариуцаж, хэт ачаалалтай ажиллаж байгаа зэргээс шалтгаалан жендэрийн салбар хорооны үйл ажиллагааны үр дүнд бий болох боломжит үр дүнг тооцоолоход хүндрэлтэй байна.

Нутгийн захиргааны байгууллага дахь жендэрийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, ажлын ачаалал зэргийг харгалзахгүйгээр хуулиар хүлээсэн чиг үүргийн гарцын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт бүгд 100 хувь байхаар тооцсоноор бодит хэрэгжилт харьцангуй доогуур үнэлэгдэж байгааг энд тэмдэглэж байна.

**1.4. Тайлан ирүүлсэн ирц, чанар**

ЖЭТБХтХ-д заасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайлан болон цахим системд шивж оруулдаг тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор тайлагнахаар журамласан байдаг бөгөөд энэ хүрээнд Хорооны Ажлын

албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Тайлан ирүүлэх тухай” 298 тоот албан бичгийг нутгийн захиргааны байгууллага (аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ)-д хүргүүлсэн. Тус албан бичигт дараах тайлан мэдээллийг ирүүлэх талаар заасан. Үүнд:

1. Нутгийн захиргааны байгууллагад ажиллаж буй албан хаагчдын 2024 оны хүйсийн тэнцвэрт байдлын жилийн мэдээ ( хавсралт 1)
2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явц, үр дүнгийн (Б-ЖЭТБ-4) мэдээ (Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 5 сарын 19-ний өдрийн А/49 дугээр тушаалаар баталсан маягт заасврын дагуу программд оруулсан)
3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан гаргасан орон нутгийн жендэрийн хөтөлбөр/арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан (хавсралт 2)
4. Нутгийн захиргааны байгууллагын дэргэдэх хороо зөвлөл, комиссын бүрэлдэхүүний мэдээлэл (хавсралт 3)
5. Аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах 2025 оны арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн хамт (хавсралт 4)
6. Жендэрийн салбар хороо (дэд хороо)-ийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай холбогдох шийдвэр (хавсралт 5)
7. Жендэрийн салбар хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн даргын товч мэдээлэл (хавсралт 6)
8. Иргэд, олон нийтэд зориулсан жендэрийн цахим тест болон удирдах албан тушаалтнуудад зориулсан жендэрийн цахим сургалтад хамрагдсан албан тушаалтнуудын тоо, мэдээлэл (хавсралт 7)
9. Жендэрийн салбар хорооны нарийн бичгийн дарга, жендэрийн мэргэжилтний батлагдсан албан тушаалын тодорхойлолт, “ЖЭТБХ салбар дундын зохицуулалт хариуцсан мэргэжилтэн”-ийг томилсон тушаал, шийдвэр (хуулбар)

Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ нь дээрх жагсаалтын 2-д заасан цахим мэдээг Үндэсний статистикийн хорооны баталсан маягтын дагуу программд шивж, жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайланг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар хавсралтын дагуу бичгээр тайлагнаж ажиллалаа.

ЖЭТБХтХ-д заасан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн 2024 оны тайланг 25 /80%/ нутгийн захиргааны байгууллага ирүүлснээс, 16 байгууллага хугацаандаа, 9 байгууллага хугацаа хоцроож ирүүлсэн бөгөөд тайлан мэдээ гаргах үйл явц төдийлөн сайн жигдрээгүй хэвээр байгааг харуулж байна. Цахим мэдээг нийт аймаг, нийслэл, дүүрэг цаг хугацаанд шивж тайлагнасны зэрэгцээ Баянгол дүүрэг цахим тайлан шивээгүй байна.

2024 онд нийт 563 нутгийн захиргааны байгууллага цахим програмд холбогдох мэдээг оруулахаас 550 байгууллага цаг хугацаанд нь шивж, баталгаажуулсан байна. Цахим програмд шивж баталгаажуулдаг энэхүү тайлан нь тайлан шивэх хугацаа дуусахад автоматаар хаагддаг бөгөөд 2020 оноос хойш бүрэн тайлагнаж хэвшээгүй хэвээр байна. Энэ нь сүүлийн жилүүдэд хороодын тоо жил бүр нэмэгдэж, шинэ ажилтнууд тайлан гаргах үйл явцад суралцаж, тодорхой цаг хугацаа шаардаж байгаатай холбоотой байгаа бөгөөд цаашид шинээр байгууллагдаж буй нутгийн захиргааны байгууллагуудад тайлагналтын чиглэлээр чиглүүлэх сургалтыг холбогдох дээд шатны нутгийн захиргааны байгууллага тогтмол зохион байгуулж хэвших хэрэгтэй байна.

**Хүснэгт 1.** Цахим тайлан шивсэн бүртгэл 2021-2024

| № | Цахим тайлан шивэх байгууллага | 2024 | | 2023 | | 2022 | | 2021 | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хяналтын тоо | Гүйцэтгэл, тоо, хувиар | Хяналтын тоо | Гүйцэтгэл, тоо, хувиар | Хяналтын тоо | Гүйцэтгэл, тоо, хувиар | Хяналтын тоо | Гүйцэтгэл, тоо, хувиар |
| 1 | Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хороо | 563 | 550 97% | 563 | 550/ 97% | 560 | 520/ 92.8% | 529 | 498/ 94.1% |

**Хүснэгт 2.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн бичмэл тайлан ирүүлсэн бүртгэл

| № | Тайлан ирүүлсэн нутгийн захиргааны байгууллага | ЖЭТБХ үйл ажиллагааны явц, үр дүнгийн бичмэл тайлан ирүүлсэн | | |
|---|---|---|---|---|
| | | Албан бичгийн дугаар | Огноо | Хугацаа хоцорсон эсэх |
| 1 | Архангай | 01/53 | 2025-01-10 | |
| 2 | Баянхонгор | 1а/31 | 2025-01-15 | Хугацаа хоцорсон |
| 3 | Булган | 1/58 | 2025-01-10 | |
| 4 | Баян-Өлгий | 6/03-20 | 2025-01-10 | |
| 5 | Говь-Алтай | 7/41 | 2025-01-10 | |
| 6 | Говьсүмбэр | | | Тайлан ирүүлээгүй |
| 7 | Дархан-Уул | 1/10-02 | 2025-01-06 | |
| 8 | Дорнод | 1/47 | 2025-01-10 | |
| 9 | Дорноговь | 01/21 | 2025-01-21 | Хугацаа хоцорсон |
| 10 | Дундговь | 01/30 | 2025-01-09 | |
| 11 | Завхан | 4/09 | 2025-01-06 | |
| 12 | Орхон | 01/106 | 2025-01-15 | Хугацаа хоцорсон |
| 13 | Өмнөговь | | | Тайлан ирүүлээгүй |
| 14 | Өвөрхангай | 1/36 | 2025-01-10 | |
| 15 | Сүхбаатар | | | Тайлан ирүүлээгүй |
| 16 | Сэлэнгэ | 01/19 | 2025-01-10 | |
| 17 | Төв | 06/42 | 2025-01-09 | |
| 18 | Увс | | | Тайлан ирүүлээгүй |
| 19 | Ховд | 2/127 | 2025-01-15 | Хугацаа хоцорсон |
| 20 | Хөвсгөл | 1/92 | 2025-01-10 | |
| 21 | Хэнтий | 4/85 | 2025-01-10 | |
| 22 | Багануур | 01/31 | 2025-01-10 | |
| 23 | Багахангай | 02/77 | 2025-01-21 | Хугацаа хоцорсон |
| 24 | Баянзүрх | 01а/157 | 2025-01-20 | Хугацаа хоцорсон |
| 25 | Баянгол | | | Тайлан ирүүлээгүй |
| 26 | Налайх | 03/351 | 2025-02-18 | Хугацаа хоцорсон |
| 27 | Сонгинохайрхан | | | Тайлан ирүүлээгүй |
| 28 | Сүхбаатар | 2/42 | 2025-01-09 | |
| 29 | Хан-Уул | 01/25 | 2025-01-15 | Хугацаа хоцорсон |
| 30 | Чингэлтэй | 3/114 | 2025-01-14 | Хугацаа хоцорсон |
| 31 | Нийслэл | 02-02/170 | 2025-01-10 | |

### 1.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний товч үр дүн

ЖЭТБХтХ-ийн 19 дүгээр зүйлд заасан нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг, 10 дугаар зүйлд заасан төрийн албанд жендэрийн тэгш байдлыг хангах баталгааны хэрэгжилтийг хангах хүрээнд аймаг, нийслэл, дүүргээс 2024 онд авч хэрэгжүүлсэн арга

хэмжээг үйл ажиллагааны болон хүрэх үр дүнгийн 46 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дунджаар 55.3% буюу 2023 оны үнэлгээ (58.8%)-ээс 3.5%-аар буурсан байна.

Иймд ахиц дэвшил, хүрсэн үр дүнгээ хадгалж, үйл ажиллагааны явц, үр дүнгийн хяналт -шинжилгээ, үнэлгээг цаг тухай бүрт нь үр дүнтэй хийж гүйцэтгэх, Хорооны Ажлын албанаас өгсөн зөвлөмж дүгнэлтийн дагуу арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

## ХОЁР. ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮН

### 2.1 Жендэрийн хариуцлагатай бодлого төлөвлөлт: Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт, ахиц дэвшил

Жендэрийн салбар хорооны үйл ажиллагаа эрчимжиж, Хороодын хуралдаан тогтмол хийгдэж байна. 2023 онд 54, 2024 онд 47 удаа ээлжит болон ээлжит бус хуралдааныг зохион байгуулж, ЖҮХ, салбар орон нутгийн ТББ, зөвлөх шинжээчид болон иргэний нийгмийн байгууллага, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах нь нэмэгдсэн байна.

Цаашид салбар хорооны бүрэлдэхүүнд хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн оролцоог хангах нь бодлого үйл ажиллагааны үр нөлөөг хувийн хэвшил, олон нийтэд хүргэхэд илүү хүртээмжтэй болох боломжтой юм. Тайланд дурдсанаар нийт 29 нутгийн захиргааны байгууллага жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагын оролцоог 8 нутгийн захиргааны байгууллага хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог хангаж ажиллаж байна.

Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргээс бусад бүх аймаг, нийслэл дүүрэгт орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын оролцоог жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүнд ажиллуулж байна.

Хэнтий, Өвөрхангай, Дорнод, Говь-Алтай, Булган аймаг болон Багахангай Баянгол Налайх, дүүрэгт Жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүнд аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчдын төлөөллийг оруулж буй туршлага бий болсон байна.

Орон нутгийн жендэрийн бодлого нь тухайн орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, төрийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжлийн аргазүйгээр дэмжихийн зэрэгцээ ЖЭТБХтХ, үндэсний, салбарын, салбар дундын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулахад чиглэгдэж байна. Хэрэгжих хугацаа дууссан болон эхний үе шат дууссан 31 орон нутгийн бодлогын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн үнэлгээ, аймаг, нийслэл, дүүргийн дотоод хяналт шинжилгээ үнэлгээ болон тухайн жилийн хэрэгжилтийн тайлан зэрэг мэдээлэлд үндэслэн орон нутгийн жендэрийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээг танилцуулж байна.

2024 оны байдлаар орон нутгийн нийт 31 жендэрийн бодлогод явцын болон үр дүнгийн хяналт шинжилгээ хийх шаардлагатай байгаагаас 17 бодлогод хяналт- шинжилгээ, үнэлгээ /үүнээс 9 нь хөндлөнгийн үнэлгээ/ хийж ажилласан байна. Түүнчлэн дээрх үнэлгээний дийлэнх нь тухайн бодлого хэрэгжиж дууссаны дараа хийгдсэн бол Багануур, Налайх дүүрэг бодлогын хэрэгжилтийн явцын үнэлгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байна.

Орон нутгийн жендэрийн бодлогын үнэлгээний үр дүн, дунджаар 2024 оны үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагатай нийт 31 бодлого төлөвлөгөөний хэрэгжилтийг дунджаар тооцоход "**үр дүн хангалтгүй**" байна.

**Хүснэгт 3.** Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн мэдээ */2025 оны 01-р сарын 10-ны байдлаар /*

| № | Нутгийн захиргааны байгууллага | Бодлого хэрэгжих үе шат/он/ | Хэрэгжилт (хувь) | Бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийгдсэн байдал, үнэлгээ хийсэн байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | Архангай | 2020-2024 | | Үр дүнгийн хөндлөнгийн ХШҮ хийх шаардлагатай. |
| 2 | Баян-Өлгий | 2018-2021 | 90.1 | 2021, ЗДТГ, ХШҮХ |
| 3 | Баянхонгор | 2019-2022 | 72.7% | Бодлогын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, Баянхонгор аймгийн Нийгмийн түншлэлийн сүлжээ ТББ, 2021 он |
| | | 2023.12.05 | - | Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай. |
| 4 | Булган | 2013-2020 | 61 | ХШҮ, Булган аймгийн ТББ-ын нэгдэл сүлжээ байгууллага- Гэрэлт ирээдүй оршихуй ТББ, 2021 |
| 5 | Говь-Алтай | 2018-2022 | 83.3 | ЗДТГ, ХШҮХ |
| 6 | Говьсүмбэр | 2019-2021 | - | Үр дүнгийн хөндлөнгийн ХШҮ хийх шаардлагатай. |
| 7 | Дархан-Уул | 2019-2021 | 60 | Дархан-Уул аймгийн ТББ-ын сүлжээ байгууллага, 2021 |
| | | 2023.02.10 | - | Явцын хяналт шинжилгээ хийх шаарлагатай. |
| 8 | Дорноговь | 2017-2021 | | Үр дүнгийн хөндлөнгийн ХШҮ хийх шаардлагатай. |
| 9 | Дорнод | 2018-2021 | 55 | Дорнод аймгийн ЛЭОС-ийн ТББ-ын сүлжээ, 2021 |
| | | 2024.01.08 | - | - |
| 10 | Дундговь | 2019-2022 | 84.2 | ЗДТГ, ХШҮХ, 2022 |
| | | 2024.01.10 | - | - |
| 11 | Завхан | 2018-2021 | - | Үр дүнгийн хөндлөнгийн ХШҮ хийгээгүй/хийх шаардлагатай. |
| | | 2024.01.11 | - | - |
| 12 | Өвөрхангай | 2019-2021 | | Үр дүнгийн ХШҮ хийх шаардлагатай. |
| 13 | Өмнөговь | 2019-2021 | 61.8 | Өмнөговь аймгийн ТББ-ын сүлжээ, 2021 |
| 14 | Орхон | 2020-2023 | 97.3 | 2023, ЗДТГ, ХШҮХ |
| 15 | Сүхбаатар | 2019-2022 | 87.5 | 2021, ЗДТГ, ХШҮХ |
| 16 | Сэлэнгэ | 2018-2021 | - | Үр дүнгийн хөндлөнгийн ХШҮ хийх шаардлагатай. |
| 17 | Төв | 2018-2021 | - | Үр дүнгийн хөндлөнгийн ХШҮ хийгээгүй. /хийх шаардлагатай./ |
| | | 2024.01 | - | - |
| 18 | Увс | 2017-2021 | 83.8 | ЗДТГ, ХШҮХ, 2022/ |
| 19 | Ховд | 2017-2021 | 92 | Ховд аймгийн ТББ-ын сүлжээ, 2021 |
| | | 2022.11.12 | - | Явцын ХШҮ хийх шаардлагатай. |
| 20 | Хөвсгөл | 2019-2021 | 72.6 | 2021, ЗДТГ, ХШҮХ |
| 21 | Хэнтий | 2020-2023 | | Үр дүнгийн ХШҮ хийх шаардлагатай. |
| | Нийслэл, дүүрэг | | | |
| 1 | Нийслэл | 2020-2025 | | Явцын ХШҮ хийх шаардлагатай. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Багахангай | 2020-2025 | | Явцын ХШҮ хийх шаардлагатай. |
| 3 | Багануур | 2020-2024 | 60.5 | Багануур дүүргийн ЛЭОС-ийн салбар байгууллага, 2021 |
| 4 | Баянгол | 2020-2025 | | Явцын ХШҮ хийх шаардлагатай. |
| 5 | Баянзүрх | 2019-2024 | 42 | Явцын ХШҮ,ЗДТГ, ХШҮХ, 2023 |
| 6 | Налайх | 2020-2025 | 70 | Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ, Орон нутгийн хөгжлийн бодлогын судлалын төв, 2023 |
| 7 | Сонгинохайрхан | 2020-2025 | - | Явцын ХШҮ хийх шаардлагатай. |
| | | 2023-01-05 | - | Явцын ХШҮ 2025 онд хийх шаардлагатай |
| 8 | Сүхбаатар | 2018-2021 | 90 | Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн судалгааны баг, IRIM, 2021 |
| 9 | Хан-уул | 2022-2025 | | Явцын ХШҮ хийх шаардлагатай. |
| 10 | Чингэлтэй | 2018-2020 | | Үр дүнгийн хөндлөнгийн ХШҮ хийх шаардлагатай. |
| Орон нутгийн жендэрийн бодлогын үнэлгээний үр дүн, дунджаар 2024 оны үзүүлэлтээр үнэлгээ 40% буюу "**үр дүн хангалтгүй**" байна. | | | | |

Орон нутгийн жендэрийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс жендэрийн дэд хөтөлбөр, бодлого стратегийн хэрэгжилтийн жил бүрийн хяналт шинжилгээг тогтмол хийх зөвлөмж өгч ажилласнаар 2024 онд 10 аймаг, нийслэл, 6 дүүрэг, нийт 17 нутгийн захиргааны байгууллага хяналт шинжилгээ хийж тайлагнасан нь 2023 оны үзүүлэлтээс 30 орчим хувиар буурсан байна.

Монгол Улсад хэрэгжиж буй орон нутгийн жендэрийн бодлого нь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг бүх шатанд нэвтрүүлэх, жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин нөхцлийг бүрдүүлэх, жендэрийн хэвшмэл ойлголтыг халж, олон нийтийг соён гэгээрүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендэрийн тэгш байдлыг хангах түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлэх гэсэн үндсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж, дараах үр дүн, сорилтыг бий болгож байна. Үүнд:

### 2.1.1.Жендэрийн хариуцлагатай төсөвлөлт: үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, зарцуулалт:

Орон нутгийн хөгжлийн сан, бэлчээр ашиглалтыг зохицуулах журам, байгаль орчныг хамгаалсны урамшуулал, ноос арьс ширний татаас, хоршоог хөгжүүлэх сан, малчны хөгжлийн сан, малчдын хамтын санаачилга, малчдын холбоо, малын индексжүүлсэн даатгал, нийгмийн даатгалын дэмжлэг, эрт тэтгэвэрт гарах нөхцөл журам, малчдын чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр, малчин өрхийн нэг хүүхдийг үнэ төлбөргүй сургах, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулах, гамшиг болон аюулт үзэгдлийн улмаас амь насаа алдсан бол гэр бүлд нь нэг удаагийн буцалтгүй тусламж олгох, малжуулах хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл зэрэг төрөөс олгож буй дэмжлэг зохицуулалтууд орон нутагт хэрэгжиж байгаа ч хөдөөд ядуурал нэмэгдсэн, хүйсийн тэнцвэргүй байдал бий болсон сөрөг үр дагаврууд бий болсныг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн Засгийн газрын тайланд дурдсан байна.

Иймд орон нутагт хүйсээр ангилсан мэдээлэл өгөгдөл цуглуулах, дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлж, бодлого шийдвэрт үр дүнтэй ашиглахад анхаарах шаардлагатай.

Эдийн засгийг сэргээх замаар хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыгнэмэгдүүлэх, орон нутагт шилжин суурьших иргэдийн

суурь хэрэгцээг хангах, орон сууцны хөнгөлөлттэй зээл олгох, жижиг дунд, бичил бизнесийг дэмжих зэрэг арга хэмжээний хэрэгжилт тодорхой үр дүнтэй, ялангуяа олгосон зээлийн 90 гаран хувийг малчдыг дэмжихэд зарцуулсан хэдий ч, үр шим хүртэгчдийн судалгаа хүйс, газар зүйн байршлаар гаргах байдал дутмаг, үнэлэлт дүгнэлт өгөх боломж хомс байна. Үүнтэй холбоотой хот сууринд чиглэсэн шилжилт хөдөлгөөн жилээс жилд өсөн нэмэгдэж, хүн амын төвлөрөл Улаанбаатар, Дархан, Эрдэнэт гэсэн цөөн тооны томоохон хот, сууринд бий болсон нь бүс нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх, бүсийн тулгуур төвийг хөгжүүлэх бодитой хэрэгцээг бий болгож байна.

ЖЭТБХтХ-д зааснаар нутгийн захиргааны байгууллага нь нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг бүрэн хангаж, тогтоосон хугацаанд Жендэрийн үндэсний хороонд тайлагнах үүрэг хүлээдэг.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тодорхой төсөв хөрөнгө шаардлагатай бөгөөд үйл ажиллагааны санхүүжилтийг тухайн жилийн төсөвт тусгаж буй байдал сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна. Санхүүжилт аль ч түвшинд нэмэгдсэн нь сайн үзүүлэлт хэдий ч жендэрийн эрх тэгш байдлыг хангах Тогтвортой хөгжлийн зорилт, үндэсний бодлого, стратеги төлөвлөгөөний зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулахад төдийлөн хангалттай бус байгаагийн зэрэгцээ жендэрээр ангилсан өгөгдөл мэдээлэл хангалтгүйгээс үр нөлөөг үнэлж дүгнэхэд бэрхшээл учруулж байна.

**Хүснэгт 4**. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төсөв зарцуулсан яам, нутгийн захиргааны байгууллагын тоо

| Он | Яам | Аймаг, нийслэл/дүүрэг |
|---|---|---|
| 2017 | 1 | 5 |
| 2018 | 4 | 7 |
| 2019 | 2 | 14 |
| 2020 | 8 | 18 |
| 2021 | 4 | 26 |
| 2022 | 7 | 24 |
| 2023 | 8 | 24 |
| 2024 | 8 | 29 |

**Эх үүсвэр**: Жендэрийн салбар зөвлөл, салбар хорооны 2022, 2023, 2024 оны тайлан

2020 оны байдлаар 18 аймаг, нийслэл жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагаанд төсөв баталж, хэрэгжүүлсэн гэж тайлагнажээ. Бусад салбар зөвлөл, салбар хороо ажлын тайландаа энэ чиглэлд шаардагдах бусад төсвийг олон улсын байгууллагын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн гэж тайлагнасан байна. (Эм Эм Си Жи ХХК, 2021).

2021 онд Сэлэнгэ, Хөвсгөл аймгаас бусад 19 аймаг, Баянзүрх, Багахангай дүүргээс бусад 7 дүүрэг, нийт 2200614.9 мянган төгрөгийг жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд зарцуулснаас 65% нь улсын төсвийн санхүүжилт байна.

2022 онд Өвөрхангай, Дорноговь, Сэлэнгэ аймгаас бусад 18 аймаг, Нийслэл болон Нийслэлийн Багахангай, Баянзүрх, Чингэлтэй дүүргээс бусад 6 дүүрэг нийт 2321671.0 мянган төгрөгийг жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд зарцуулснаас 72% нь улсын төсөв, 28% нь олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилт байна.

2023 онд Архангай, Дорноговь, Сэлэнгэ, Хэнтий, Нийслэл, Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй дүүргээс бусад нутгийн захиргааны байгууллагууд 693996,0 мянган төгрөгийг жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд зарцуулсан гэж тайлагнасан байна.
2024 онд Увс аймаг болон Нийслэлийн Баянгол дүүргээс бусад нутгийн захиргааны байгууллагууд 2984631.0 мянган төгрөгийг жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд зарцуулсан. Тэдгээрийн 80.8% нь улсын төсөв, 19.2 % нь олон улсын байгууллагын техник тусламж болон бусад санхүүжилт байна. (Б-ЖЭТБ-1 маягт)

**2.1.2. Жендэрийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаа:**

Нутгийн захиргааны байгууллагууд нь жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний аян хөдөлгөөнд нэгдэж, идэвхтэй оролцох, жендэрийн талаарх олон нийт болон төрийн албан хаагчдад зориулсан сургалтыг бүх шатанд зохион байгуулах, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусгай кабинетийн тоог нэмэгдүүлэх, тэдний үзлэг оношилгоонд хамрагдах хандлага дадлыг нэмэгдүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг бууруулах, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх бодлого, үйл ажиллагааг орон нутгийн төсөв, санхүүжилтээр тодорхой хүчин чармайлт гарган хэрэгжүүлж ажиллаж байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд 2022 онд 167, 2023 онд 250, 2024 онд 241 байгууллага хамт олон үндэсний хэмжээнд нэгдсэн бөгөөд Өмнөговь, Хэнтий, Говьсүмбэр аймаг, Багахангай дүүргийн ЗДТГ-аас бусад бүх аймаг, нийслэл дүүрэг аянд идэвхтэй нэгдэж тайлан мэдээллээ өгч ажилласан байна.

Аяны хүрээнд 2024 оны 11-р сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд олон нийтэд хүргэсэн 212 мэдээ мэдээлэл, контентыг давхардсан тоогоор нийт 1.283.000 хүнд хүрсэн талаар мониторинг судалгааны тайланд дурдсан байна.

Түүнчлэн орон нутагт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, хөгжлийн байгууллагуудтай нэгдсэн уулзалтыг зохион байгуулж, төсөл хөтөлбөрийн зорилго зорилтыг тухайн орон нутгийн жендэрийн бодлогыг дэмжихэд чиглүүлж ажиллаж байгаа туршлагууд бий болж байна. ТББ-тай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ нэмэгдэж, зохион байгуулж байгаа сургалт арга хэмжээнд оролцоог хангаж, энэ талаараа тайлагнаж хэвшиж байна.

Төрийн албан хаагч болон иргэдийн жендэрийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх хүрээнд 2023 онд 333 сургалтад 983 байгууллага, 23980 иргэн, 2024 онд 636 сургалтад 1503 байгууллага, 48531 иргэн хамруулсан байна.

**Зураг 1**.Сургалтын тоо, хамрагдсан байгууллагаар




| | 2023 Сургалтын тоо | 2023 Хамрагдсан байгууллага | 2024 Сургалтын тоо | 2024 Хамрагдсан байгууллага |
|---|---|---|---|---|
| Нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулсан сургалт | 333 | 983 | 636 | 1503 |
| Яам зохион байгуулсан сургалт | 38 | 148 | 62 | 173 |
| ЖҮХ-ны Ажлын албанаас зохион байгуулсан сургалт | 105 | 80 | 55 | 110 |

**Хүснэгт 5**.Сургалтад оролцогч, хүйсээр

| Сургалт зохион байгуулсан байгууллага | 2023 | | | 2024 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нийт оролцогч | эр | эм | Нийт оролцогч | эр | эм |
| ЖҮХАА | 10017 | 3977 | 6040 | 2744 | 1346 | 1398 |
| ТЗТБ/ Яам | 3726 | 1659 | 2067 | 3009 | 1663 | 1346 |
| НЗБ/ Нийслэл, дүүрэг, аймгийн ЗДТГ | 23980 | 10176 | 13804 | 48531 | 17549 | 30982 |
| | 37723 | 15812 | 21911 | 54284 | 20558 | 33726 |

Орон нутгийн жендэрийн салбар хороод ажилтнуудын жендэрийн мэдлэг ойлголтыг сайжруулахад анхаарч ажиллаж байгаа нь мөн онуудад зохион байгуулагдсан сургалт болон оролцогчдын тоо 1.5-2 дахин өссөнөөс харагдаж байна.

Сургалтад оролцогчдын хүйсийн хувьд үндэсний хэмжээнд 2023 онд жендэрийн сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд оролцогчдын 42.4% эрэгтэй байсан бол 2024 онд 36.1% нь эрэгтэйчүүд болж 6.3 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд яамдын хувьд оролцогчдын 1.3-9% нь удирдах ажилтан, аймаг, нийслэл, дүүргийн хувьд 3 хувь нь удирдах албан хаагч байгаа нь сургалтыг энэ бүлэгт чиглүүлэх хэрэгцээг харуулж байна.

Цаашид шинээр ажилд орж буй албан хаагчдад өгөх, чиглүүлэх болон давтан сургалт, удирдах ажилтнуудад зориулсан сургалтад оролцогчдыг нарийн бүртгэж, сургалтын агуулга, зорилго, чанар үр дүнд үнэлгээ хийж ажиллах зорилгоор бэлтгэсэн жендэрийн сургагч багш нарын нэгдсэн платформыг хөгжүүлж аймаг, нийслэл, дүүргийн жендэрийн мэргэжилтэн, бэлтгэгдсэн сургагч багш нар нийт 155 хүнийг бүртгэсэн нь бүртгэгдвэл зохих нийт жендэрийн мэргэжилтэн шинжээч, багш нарын 30 орчим хувьд хүрэхгүй байна. Иймд цаашид орон нутгаас нэр өгч бэлтгэсэн жендэрийн сургагч багш нарыг бүртгэлжүүлж, давтан сургах, тэднийг сургалт нөлөөллийн ажилд идэвхтэй оролцуулах шаардлагатай байна.

**Зураг 2.** Удирдах ажилтанд зориулсан цахим модуль болон Иргэд, олон нийтэд зориулсан жендэрийн цахим тестийн танилцуулга



"Удирдах ажилтанд зориулсан жендэрийн цахим сургалт" болон "Иргэд, олон нийтэд зориулсан жендэрийн цахим тест"-ийг нэвтрүүлж, иргэд болон аль ч байгууллагын удирдах ажилтан богино хугацаанд жендэрийн талаарх ойлголт, мэдлэгээ бататгах боломжийг бүрдүүллээ.

Удирдах ажилтны жендэрийн цахим сургалтад 2025 оны 4 сарын 28-ны өдрийн байдлаар нийт 19 аймаг, 9 дүүргийн 3249 удирдах ажилтан хандалт хийж, 624 удирдах ажилтан 80- аас дээш хувийн амжилттай суралцаж, гэрчилгээ авсан байна. Булган, Увс,

Хэнтий, Говь-Алтай, Говьсүмбэр, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг, Багануур, Багахангай дүүргийн хувьд хангалтгүй хамрагдсан байна.

**Хүснэгт 6.** Удирдах ажилтанд зориулсан цахим сургалтад хамрагдсан байдал, аймгаар

| Нутгийн захиргааны байгууллага | Нийт хандсан удирдах ажилтан | Гэрчилгээ авсан удирдах ажилтан | Чанар амжилт |
|---|---|---|---|
| Архангай | 34 | 5 | 14.7 |
| Баян-Өлгий | 23 | 10 | 43.5 |
| Баянхонгор | 25 | 7 | 28.0 |
| Булган | 9 | 0 | 0.0 |
| Говь-Алтай | 10 | 1 | 10.0 |
| Говьсүмбэр | 3 | 1 | 33.3 |
| Дархан-Уул | 31 | 15 | 48.4 |
| Дорноговь | 65 | 13 | 20.0 |
| Дорнод | 367 | 52 | 14.2 |
| Дундговь | 97 | 15 | 15.5 |
| Завхан | 828 | 57 | 6.9 |
| Орхон | 12 | 7 | 58.3 |
| Өвөрхангай | 22 | 9 | 40.9 |
| Өмнөговь | 21 | 11 | 52.4 |
| Сүхбаатар | 8 | 3 | 37.5 |
| Сэлэнгэ | 9 | 2 | 22.2 |
| Төв | 115 | 13 | 11.3 |
| Увс | 8 | 0 | 0.0 |
| Ховд | 87 | 16 | 18.4 |
| Хөвсгөл | 244 | 37 | 15.2 |
| Хэнтий | 8 | 1 | 12.5 |

